



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 11 сарын 18 өдөр

Дугаар А/696

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.а, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 09/02 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн 3.3.81 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Соёлын биет бус өвийг хамгаалах “Соёлын өв-Хөгжлийн дархлаа” форумд зарцуулах 3.364.000 (Гурван сая гурван зуун жаран дөрвөн мянга) төгрөгийн зардлыг хавсралтаар баталсугай.

2. Дээрх 3.364.000 (Гурван сая гурван зуун жаран дөрвөн мянга) төгрөгийг аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

3. “Соёлын өв-Хөгжлийн дархлаа” форумын бэлтгэл ажлын хэрэгжилтийг сайтар ханган ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газар (Ж.Пүрэвсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101319

Аймгийн Засаг даргын 2019 оны 11  
дугаар сарын 18 ны өдрийн 4696 дугаар  
захирамжийн хавсралт

“СОЁЛЫН ӨВ-ХӨГЖЛИЙН ДАРХЛАА” ФОРУМЫГ  
ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Тоо хэмжээ	Нийт үнэ
1.	Үдийн цай	Тоо	1000	70	70000
2.	Өдрийн хоол	Тоо	10000	70	700,000
3.	Улаанбаатар хотоос оролцогчдын замын зардал	Тоо	21000	2 *2	84,000
4.	Улаанбаатар хотоос оролцогчдын байр	тоо	40000	2*2	160,000
5.	Соёлын өв өвлөн уламжлагч нарт батламж	тоо	25000	18	450,000
6.	Шагнал	тоо	100,000	18	1800,000
7.	Стикер	тоо	100,000	1	100,000
Нийт					3,364,000